

11 Би бол чиний хүч чадал

11.1 Эзэн бол миний хүчин

²⁷“Миний зам ЭЗЭНээс нуугдаж,
үйлсийг минь миний Бурхан мартсан” гэж чи яагаад өгүүлнэ
вэ, Иаков оо?

Чи юунд ярина вэ, Израиль аа?

²⁸Чи мэдэхгүй гэж үү?

Чи сонсоогүй гэж үү?

Мөнхийн Бурхан болох ЭЗЭН дэлхийн хязгаарыг Бүтээгч нь
эцэж туйлддаггүй юм.

Түүний ухаан нь хязгааргүй.

²⁹Тэр ядарсанд тэнхээ өгч,
чадал дутагдсанд нь хүч нэмдэг.

³⁰Залуу хүн ч ядарч сульдан,
идэр хөвгүүд ч бүдэрдэг.

³¹Харин ЭЗЭНд найдагчдын хүч нь шинэчлэгдэнэ.

Тэд бүргэд мэт жигүүр дээрээ элин халина.

Тэд гүйхдээ үл ядран, алхахдаа үл цуцна. (Иса 40:27-31АБ
2004)

[] Итгэдэг хүмүүст Тэр хүч чадал өгч чадна гэдэгт та итгэдэг үү?

11.2 Хэнээс тусламж хүсэх вэ ?

³Алсаас ирэх сүйрэл ба шийтгэлийн өдөр та нар юу хийх юм
бэ? Та нар хэн уруу тусламж гуйн зугтах вэ? Мөн
өөрсдийнхөө алдрыг хаана орхих вэ? ⁴Олзлогсдын дунд
бөхийн, алагдсан хүмүүсийн дунд унахаас өөр юу ч үлдэхгүй.
Энэ бүхнээс үл хамааран, Түүний уур хилэн эргэхгүй, Өөрийн
мутраа сунгасан хэвээр байна. (Иса 10:3-4 АБ 2004)

11.3 Чи яг л хээрийн өвс шиг

⁶Нэгэн дуу “Дуудагтун” гэсэнд би “Би юуг дуудах вэ?” гэж
хариулав. Бүх махан бие нь өвс бөгөөд түүний бүх сүр
жавхлан нь талын цэцэг мэт юм. ⁷ЭЗЭНий амьсгал дээрээс нь
үлээвэл өвс хатаж, цэцэг гандана. Хүмүүс үнэхээр өвс юм.

⁸Өвс хатаж, цэцэг гандана. Харин бидний Бурханы үг мөнхөд тогтоно. (Иса 40:6-8 АБ 2004)

[] Түүний сууринаас ба үгнээс гадуурх бүх байгууламж нь түр зуурынх юм гэдгийг та мэдэх үү?

11.4 Соломоны эдгээр зүйлийг мэдэх

Энэ нь бэлэг юм; үгийг дагахад хүч чадал дээрээс ирдэг; бидний үндэс бол дэлхий дээр биш харин дээрээс юм.

¹¹Бүх юмыг Тэр тухайн цагт нь сайн сайхнаар бүтээсэн бөгөөд хэдийгээр хүн Бурханы үйлдсэн ажлыг эхнээс эцсийг нь хүртэл ойлгохгүй ч гэсэн Тэр тэдний зүрхэнд үүрд мөнхийг байгуулсан билээ. ¹⁴Бурханы хийсэн болгон үүрд мөнхөд үлддэгийг би мэдлээ. Түүнд нь нэмэх буюу түүнээс нь хасах юу ч байхгүй аж. Бурхан ийн ажилладгийн учир нь хүмүүс Түүнээс эмээхийн тулд юм. (Номлогчийн Үгс 3:11,14 АБ 2004)

¹⁸Сайн бөгөөд жаргалтай байхыг энд л би үзлээ. Энэ нь юу хэмээвээс идэх, уух хийгээд Бурханаас өөрт нь өгөгдсөн амьдралынхаа цөөхөн жилүүдийн турш наран доор хөдөлмөрлөсөн ажил бүхнээрээ өөрийгөө баясгах явдал байлаа. Учир нь энэ л түүний хувь хишиг аж. ¹⁹Бурханаас эд баялаг, хөрөнгө зоорь авсан хүн бүрд Тэр тэдгээрийг эдэлж, хэрэглэх эрх олгож мөн өөрийн хөдөлмөрөөс баярлаж, хувь хүртэхийг зөвшөөрдөг. Энэ нь Бурханы бэлэг мөн. (Номлогчийн Үгс 5:18-19 АБ 2004)

¹²Хэдийгээр нүгэлтэн зуу зуун удаа бузар мууг үйлдэж, амьдрал нь уртассаар байх авч, Бурханаас эмээгч тэр нэгэн, Түүний өмнө нээлттэйгээр хандагч нэгэн нь илүү дээр юм гэдгийг би мэдэв (Номлогчийн Үгс 8:12 АБ 2004)

¹³Энэ бүхнийг сонордоод, дүгнэхэд Бурханаас эмээж, Түүний тушаалыг дагагтун. Энэ нь хүн бүхэнд хамаарна. ¹⁴Бурхан сайн, муу гэж ялгалгүй нууцлагдсан юмс бүрийг, бүх үйлсийг шүүлтэд аваачих болно. (Номлогчийн Үгс 12:13-14 АБ 2004)

[] Бурхан үргэлж зөв юм хийдгийг та мэдэх үү?

11.5 Бурханы эмтэрсэн зүрх

¹“Би одоо хайртдаа зориулж, Түүний усан үзмийн талбайн тухай хайртынхаа дууг дуулъя. Миний хайрт маш үржил шимтэй гүвээн дээр усан үзмийн талбайтай байсан юм. ²Тэр эргэн тойрныг нь малтаж, чулуунуудыг нь зайлуулаад, шилмэл усан үзмийг суулгаж, талбайн голд цамхаг босгоод, түүний дотор усан үзмийн шахуурга суулгаж гэнэ. Тэгээд Тэр сайхан усан үзэм гарна гэж хүлээж байтал зэрлэг жимс ургажээ.

³Одоо Иерусалимын оршин суугчид, Иудагийн эрчүүд ээ! Би болон Миний усан үзмийн талбайн хоорондохыг шүүгтүн!

⁴Усан үзмийн талбайдаа Миний хийгээгүй өөр юуг Би хийх ёстой байсан юм бэ? Сайн усан үзэм гарна гэж Би хүлээж байхад яагаад зэрлэг жимс гарсан бэ?

⁵Одоо Би Өөрийн усан үзмийн талбайд юу хийх гэж байгаагаа та нарт өгүүлье. Би түүний хайс шивээг авч хаяад, шатаана. Би ханыг нь нурааж талхлагдсан газар болгоно.

⁶Би талбайг эзгүйрүүлэн хаяад, тайрч арчлахгүй, зээтүүдэхгүй.

Харин өргөст бут, үүргэнэ ургана.

Түүн дээр бороо бүү оруул гэж Би үүлэнд тушаана”.

⁷Яагаад гэвэл түмэн цэргийн ЭЗЭНий усан үзмийн талбай бол Израилийн гэр, Түүний таалан соёрхдог ургамал нь Иудагийн эрчүүд юм.

Тэр шударга үнэнийг эрсэн боловч, цус урсгахыг үзэв.

Зөвийг эрсэн боловч, зовлонт дууг сонсжээ. (Иса 5:1-7 АБ 2004)

¹“Гуйгаагүй хүмүүст Би Өөрийгөө илчилж,

Намайг эрээгүй хүмүүст Би олдов.

Миний нэрийг дуудаагүй үндэстэнд

“Би энд байна, Би энд байна” гэж Би айлдав.

²Өөрийн бодлыг дагаж, буруу замаар явагч,

бослого гаргагч ард түмэн уруу Би бүхэл өдрийн турш мутраа сунгасан.

³Энэ ард түмэн бол Миний нүүрэн дээр Намайг байнга доромжлон, цэцэрлэгт тахил өргөн, тоосгон дээр үнэртнийг шатааж,

⁴булшнуудын дунд сууж, нууц газруудад шөнийг өнгөрөөн, гахайн мах идэн, савандаа бузар махны шөлийг хийдэг бөгөөд,

⁵“Зогс. Над уруу бүү ойртогтун.
Учир нь би чамаас илүү ариун” гэж хэлдэг.
Тэд бол Миний хамарт үнэртэх утаа,
бүх л өдөржин шатдаг гал юм.

⁶“Үзэгтүн, энэ нь Миний өмнө бичигдсэн.
Би дуугүй байхгүй, харин буцааж төлнө.
Түүгээр ч үл барам Би тэдний өвөрт нь төлнө.

⁷Ингэхдээ та нарын хилэнц хийгээд та нарын эцэг өвгөдийн хилэнцийг хоёуланг нь хамтад нь төлнө” гэж ЭЗЭН айлдаж байна. (Иса 6 5:1-7 АБ 2004)

[] Бурханд сэтгэл хөдлөл, хайр байдгийг та мэдэх үү?

11.6 Хөөрхий еэ!

А. Бурханы эсрэг ярьдаг нэгэнүүд

⁹Бүтээгчтэйгээ маргалдагчид хөөрхий еэ! Шавар сав нь газрын савнуудтай хамт байг. Шавар нь ваарчиндаа “Чи юу хийж байна вэ?” гэж хэлэх үү? Эсвэл ийж байгаа юм чинь “Тэр гаргүй юм байна” гэж хэлнэ гэж үү? (Иса 45:9 АБ 2004)

Б. Бурханы эсрэг нууцаар ажилладаг нэгэнүүд

¹⁵Өөрсдийн санаагаа ЭЗЭНээс ор тас нууцалж, үйлсээ харанхуй газарт хийж, “Хэн биднийг харах юм бэ?” “Хэн биднийг мэдэх вэ?” гэж хэлдэг хүмүүс гаслантай яа. ¹⁶Та орвонгоор нь эргүүлжээ! Ваарчинг шавартай адилтган үзэж болох уу? Бүтээгдсэн зүйл нь бүтээгчдээ хандан “Тэр намайг хийгээгүй” гэх юм гэж үү? Ваар нь ваарчиндаа хандан “Тэр мулгуу хүн” гэж өгүүлэх үү? (Иса 29:15-16 АБ 2004)

Г. Амьдралын эцэг эхийн эсрэг ярьдаг нэгэнүүд

¹⁰Эцэгтээ “Та юу төрүүлэв?”, ээждээ “Та юу гаргачихсан юм бэ?” гэж ярьдаг хүн хөөрхий еэ!”. (Иса 45:10 АБ 2004)

Д. Урвагчид хөөрхий еэ

¹Өөрсдийг чинь сүйтгээгүй байхад сүйтгэгч, өөрсдийг нь дээрэмдээгүй байхад бусдыг дээрэмдэгчид харамсагтун. Та нар бусдыг сүйтгэхээ болиход, өөрсдийг чинь сүйтгэнэ.

Та нар бусдыг дээрэмдэхээ зогсоход, та нарыг өөрсдийг чинь дээрэмдэнэ. (Иса 33:1 АБ 2004)

Е. Нүднийхээ өмнө мэргэн нэгэнүүд

²¹Өөрийнхөө нүдэнд мэргэн болж, өөрсдийнхөө бодолд ухаалаг байгчид гаслантай яа! (Иса 5:21 АБ 2004)

Ё. Архины баатрууд ба Бурханы хуулийг эсэргүүцдэг нэгэнүүдэд

²²Дарс уухдаа баатар, хатуу архи найруулахдаа зоригтой байгчид гаслантай яа!

²³Хахуулиас болж нүгэлтнийг зөвтгөж, шударга хүмүүсийн зөв байдлыг зайлуулагчид гаслантай яа!

²⁴Тийм учраас галын хэл сүрлийг түймэрдэн, галын дөлд хуйхлагдахын адил, тэдний үндэс нь өмхөрсөн мэт болж, тэдний цэцэг нь тоос шиг хийснэ. Учир нь тэд түмэн цэргийн ЭЗЭНий хуулийг үл тоомсорлон, Израилийн Ариун Нэгэний үгийг үзэн ядсан.

²⁵Үүний улмаас ЭЗЭНий уур хилэн Өөрийн ард түмний эсрэг шатаж, тэдний эсрэг мутраа сунгаж, тэднийг цохиж унагав. Уул хөдлөн, тэдний хүүр нь гудамжнуудын голд хог хаягдал мэт хэвтэнэ.

Үүгээр Түүний уур хилэн эргэсэнгүй, Тэр мутраа сунгасан хэвээр байна. (Иса 5:22-25 АБ 2004)

Ж. Үнэнийг гуйвуулах

²⁰Мууг сайн, сайныг муу гэж нэрлэгчид, харанхуйг гэрэл, гэрлийг харанхуйгаар солигчид, гашууныг амттай, амттайг гашуунаар орлуулагчид гаслантай яа! (Иса 5:20 АБ 2004)

Ч. "Бурхан яарах болтугай" гэж хэлдэг хүмүүс

¹⁸Худал хуурмагийн аргамжаар шударга бус явдлыг авчирч, тэрэгний татлагаар нүглийг татагчид гаслантай яа.

¹⁹“Тэр түргэн хийж, Өөрийн ажлаа яаравчлаг. Бид үзмээр байна. Израилийн Ариун Нэгэний зорилго

ойргон өнгөрөх болтугай. Бид мэдмээр байна” гэж өгүүлэгчид гаслантай яа! (Иса 5:18-19 АБ 2004)

- [] Та нарын зүрхэндээ Бүтээгчтэй зөрчилдөж байна уу?
- [] Та Бурхан бүх зүйлийг хардаг, Түүнээс юуг ч нууж боломжгүй гэдгийг мэдэж байсан уу?
- [] Бардам зан сүйрлийн урьтлал гэдгийг та мэдэх үү?
- [] Тэнэгүүд үхлийг элэглэж, Бурхан тэднийг мунхаг гэж дууддагийг та мэдэх үү?
- [] Үнэнийг хэн, яагаад гуйвуулдгийг та мэдэх үү?

11.7 Таны хэлсэн үг таныг илчлэх болно

¹³ЭЗЭН зарга мэдүүлэхээр босож, хүмүүсийг шүүхээр зогслоо.

¹⁴ЭЗЭН Өөрийн ард түмний ахлагчид болон ноёдтой хамт шүүхэд орж байна.

“Усан үзмийн талбайг та нар цөлмөсөн.

Ядуусаас дээрэмдсэн олз чинь та нарын гэрт бий.

¹⁵Миний ард түмнийг дарлаж,

ядуусын нүүрийг нунтаглана гэдэг чинь юу гэсэн үг вэ?” гэж түмэн цэргийн БУРХАН Эзэн айлдаж байна. (Иса 3:13-15 АБ 2004)

¹Хүчирхэг хүн ээ, чи яагаад бузар муугаар бахархдаг вэ? Бурханы хайр энэрэл бүхэл өдөржин тэсвэрлэдэг.

²Худал хуурмагийн ажилчин аа, чиний хэл Хурц тонгорог мэт сүйрлийг сэддэг.

³Чи сайнаас илүүгээр бузар мууг хайрладаг

Үнэнийг ярихаасаа илүүгээр худлыг хайрладаг. ⁴Зальт хэл ээ, (Дуулал 52:1-4 АБ 2004)

¹Шүүгдэхгүйн тулд чи бүү шүү. ²Учир нь та нар яаж шүүнэ, түүнчлэн шүүгдэнэ. Та нарын хэмжүүрийн жишиг өөрсдийг чинь хэмжинэ. и хөнөөлт үг бүрийг хайрладаг. (Мат 7 :1-2 АБ 2004)

Болгоомжлогтун: Эдгээр (таны хэлсэн үгс) нь таныг энэ дэлхий дээр байхад эцсийн шүүлтийн өдөр мэдэх илчлэх болно. Наманчил!

[] Хүмүүс Бурханы үг ба өөрсдийн жишгээр шүүгдэх болно гэдгийг та мэдэж байсан уу?

11.8 Таны зөрчсөн зүйл таныг илчлэхболно

¹Шударга бус тогтоолыг тогтоож, зөв бус шийдвэр бичигчид нь гаслантай яа! ²Ингэснээрээ тэд ядуусыг шударга явдлаас зайлуулж, Миний ард түмний үгээгүйчүүдийг үнэн зөвөөс холдуулдаг. Ингэж тэд бэлэвсэн эмэгтэйчүүдийг өөрсдийн олз болгон, өнчин хүүхдүүдийг дээрэмддэг . (Исаиа 10 :1-2 АБ 2004)

[] Хүмүүсийг халамжлах ба Бурханы өмнө хариуцлага хүлээх эрх мэдэл Бурханаас өгөгдсөн гэдэгт итгэдэг үү?

11.9 Та юу дэмий үрсэн бэ? Орон зай, газар, эзэмшил

⁸Ямар ч зайгүй болтол нь байшин дээр байшин нэмж, талбайг талбайтай нь нийлүүлэгчид гаслантай яа! Та нар газрын дунд ганцаараа амьдрах гэж ингэжээ. ⁹Миний чихэнд түмэн цэргийн ЭЗЭН “Үнэхээр, олон байшингууд хоосорч, том сайхан нь хүртэл эзэнгүй болно. ¹⁰Усан үзмийн арван акр газар нэг бат дарс гаргаж, нэг омер үр нь нэг ефа тариа ургуулна” гэж тангараглав. ¹¹Хатуу архины хойноос хөөцөлдөн өглөө эрт босон, дарсанд цохиултлаа үдэш орой болтол байгчид гаслантай яа! ¹²Тэдний найр нь лир, босоо ятга, хэнгэрэг, лимбэ, дарсаар хөгжинө. Гэвч тэд ЭЗЭНий үйлсийг үл анхаарч, Түүний мутрын ажлыг тунгааж бодохгүй. ¹³Миний ард түмэнд мэдлэг дутсанаас болж тэд цөлөгдөн, тэдний хүндэт хүмүүс нь өлсөж, олон түмэн нь цангаж зовно. ¹⁴Тиймээс Үхэгсдийн орон хоолойгоо өргөсгөн, амаа хязгааргүй ангайлгав. Иерусалимын сүр жавхлан, олон түмэн, түүний дуу чимээ, хөгжил, баясал тийшээ бууна. ¹⁵Хүн номхтгогдож, хүн басамжлагдана. Бардам хүний нүд ч басамжлагдана. ¹⁶Гэвч түмэн цэргийн ЭЗЭН шүүхээр өргөмжлөгдөж, ариун Бурхан ариун байдлаа үнэн зөв дотор үзүүлнэ. ¹⁷Хурганууд өөрийн бэлчээрт байгаа шиг идээшилж, баячуудын орхисон газарт харийнхан хооллоно. (Исаиа 5 :8-17 АБ 2004)

[] Их Эзэний тухай мэдлэг дутмаг байх нь таныг сүйрэлд хүргэх болно гэдгийг та мэдэж байсан уу?

Ядуусын хашхирахыг би сонсох болно

²⁷Учир нь тэр бол түүний цорын ганц бүтээлэг нь, биеийнх нь хувцас билээ. Тэр хүн өөр юу нөмөрч унтах вэ? Тэр Над уруу хашхирахад Би сонсох болно. Учир нь Би нигүүлсэнгүй билээ. (Египетээс гарсан нь 22 :27 АБ 2004)

²³Миний тэнгэр элч чиний өмнө явж, чамайг аморичууд, хитчүүд, перизчүүд, канаанчууд, хивичүүд, иебусчуудын нутагт аваачна. Би тэднийг бүрмөсөн устгах болно. ²⁷Би Өөрийн аймшгийг чиний өмнө явуулж, чиний очих газрын бүх ард түмнийг самууралд унаган, бүх дайсны чинь нурууг чамд харуулах болно. (Египетээс гарсан нь 23 :23, 27 АБ 2004)

[] Шударга бус явдлын хашигираан аягыг дүүргэхэд шүүлтийн цаг ирэх болно гэдгийг та мэдэх үү?